



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 03

Номгон

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж,
тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл
ажиллагааны үр дүн, үр нөлөөг
нэмэгдүүлэх тухай

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн 54 байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 36 байгууллага буюу 66,7 хувь нь 70 хувиас дээш, 18 байгууллага буюу 33,3 хувь нь 70 хувиас доош үнэлэгдсэн байна.

Бодлогын болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн тайланг дутуу, хугацаа хоцроох, огт ирүүлэхгүй байх, тайлагналтын шалгуур үзүүлэлт, суурь болон хүрсэн төвшинтэй харьцуулан бодит үр дүнгээр тайлагнадаггүй зэрэг зөрчил дутагдал дахин давтагдаж, улмаар нялхсын эндэгдэл 9,5 промилль болж, өмнөх оноос 2,0 промилиор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 12,6 промилль болж, өмнөх оноос 0,8 промилиор өссөн, охидын төрөлт өмнөх оноос 29% -иар өссөн, 439 гэмт хэрэг бүртгэгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 11 нэгжээр буюу 18.4 хувиар өссөн, 217 төрийн албан хаагч зөрчилд холбогдсон, үүний дотор удирдах ажилтнууд архи, согтууруулах ундаа хэрэглэж, зөрчил гаргаж байгаа нь сум, байгууллагын дарга, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлага, бие биедээ тавих зарчимч шаардлага, ажилдаа хандах хандлага буурсантай холбон дүгнэж байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн үр дүн, үр нөлөө, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах, зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

1200132

Нэг.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нарт

1.1.Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх талаар бодлого, хөтөлбөр гаргах, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах талаар тусгаж, хэрэгжүүлэх;

1.2.Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, орон нутагт зонхилон тохиолдох өвчлөл, эндэгдлийг бууруулах үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлж, оролцоог нэмэгдүүлэн үр дүнг тооцох;

1.3.Эх, нялхсын эндэгдэлгүй аймаг болох зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх;

1.4.Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд иргэдээ 100 хувь хамруулах, охидын төрөлтийг багасгахад чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;

1.5.Сум, байгууллагын хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, журам, стандартыг хэрэгжүүлж ажиллах;

1.6.“Нээлттэй Баянхонгор” төслийн 6 зорилтыг хэрэгжүүлэх;

1.7.Хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр гарсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлж, дүгнэх ажлыг бүх шатанд эрчимжүүлэх;

1.8.Аймгийн ойн нэгдсэн бодлого боловсруулж, тэрбум мод үндэсний хөдөлгөөний ажилтай уялдуулан хэрэгжүүлэх;

1.9.E-mongolia цахим үйлчилгээ, ERP системийн ашиглалтыг сайжруулах, байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулах;

1.10.Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн талаарх тайланг оновчтой, хугацаанд нь тайлагнах чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;

1.11.Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд сум, агентлаг, босоо болон орон нутгийн өмчийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах ажлын үр нөлөө, үр дүнг дээшлүүлэх;

Хоёр. Сумдын Засаг дарга, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын дарга нарт:

2.1.Төрийн байгууллагуудын нийт албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах, архины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршгийг сурталчлан таниулах, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр бодит ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.2.Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх, ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг бүх шатанд зохион байгуулах;

2.3.Нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэгдсэн цогц арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;

2.4. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Авлигатай тэмцэх жил”-ийн ажлын хэрэгжилтийг хангах, гэмт хэргийг бууруулах, авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулах;

2.5.Авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авч, авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах ажиллагааг хянах, бүртгэх;

2.6.Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийг хэрэгжүүлэн үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай, үнэлгээ бууруулан дүгнэгдсэн арга хэмжээнүүдийг эрчимжүүлж ажиллах;

2.7.Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам, аймгийн Засаг даргын 2023 оны А/05 дугаар захирамжаар батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд оруулсан өөрчлөлтүүдийг төрийн албан хаагчдаар судлуулан хэрэгжүүлэх;

2.8.Төрийн албан хаагчдын нөөцийг бүрдүүлэх, албан хаагчдын үүрэг, хариуцлага, ажлын уялдаа холбоог сайжруулан, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй

хандсан албан хаагчдад хариуцлага тооцож, дүнг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;

2.8.Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, баримтыг стандарт шаардлагын түвшинд хөтлөх, баримтжуулах, хяналт арга зүйгээр хангах, нийт ажилтнуудын хагас бүтэн жилийн ажлын гүйцэтгэл үнэлгээнд баримтжуулалт, архивлах ажлыг оруулан тооцох, урьд онуудын баримтыг архивд бүрэн хүлээн авах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, зэрэг архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах

2.9.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлт, суурь болон хүрсэн түвшинтэй харьцуулан бодит үр дүнгээр тайлагнаж хэвших, энэ талаар төрийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах;

2.10.Үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг эрчимжүүлэх, шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх талаар санал, санаачилга гаргах ажиллах;

2.11.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар дорвитой арга хэмжээ зохион байгуулж, төрийн үйлчилгээний талаар иргэдийн саналыг цахимаар авч хэрэгжүүлэх ажлыг улирал бүр зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах;

2.12.Засгийн газрын тэргүүлэх чиглэлд орсон ногоон байгууламж, хог хаягдал, цахим засаглал болон байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг хангах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, үр дүнг журамд заасан хугацаанд тайлагнах;

2.13.Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, журам, стандартыг хэрэгжүүлж ажиллах;

2.14.Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн талаарх тайланг оновчтой, хугацаанд нь тайлагнаж хэвших;

2.15.Хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр гарсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг дурдсан хугацаанд тайлагнаж хэвших;

2.16.Сум, байгууллагын удирдлагууд байгууллагын дотоодын хяналтыг өндөржүүлж ажиллах;

2.17.Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн үр дүнтэй ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Гурав. Албан даалгаврын хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж байхыг сумдын Засаг дарга,төрийн бүх шатны байгууллагын удирдлагуудад даалгасугай.

Дөрөв. Сум, агентлаг, босоо болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2023 оны эхний хагас жилийн Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан ахиц өөрчлөлтийн талаар Засаг даргын удирдлагын багт танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга /Л.Мандал/-д үүрэг болгосугай.

Тав. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь) -д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН